





# Сургуулийн өмнөх боловсролын байгууллага



# ТАНИЛЦУУЛГА



1960 онд “Сангийн далайн хүүхдийн цэцэрлэг” нэртэйгээр Оч нэгдлийн хөрөнгөн дээр тулгуурлан ясли, цэцэрлэгийн насны 15 хүүхэдтэй 1 хүмүүжүүлэгч, багштай улирлын чанартайгаар байгуулагдсан түүхтэй.

Анхны хүмүүжүүлэгч багшаар Г. Норжин , Н.Сугарсүрэн Буяндэлгэр нарын хүмүүс ажиллаж байжээ. 1968 оны 8 дугаар сараас эхлэн 30 хүүхэд, хүмүүжүүлэгч багш, асрагч, нярав, тогооч зэрэг орон тоотой байнгын ажиллагаатай цэцэрлэг болсон. Энэ үед 3 өрөөтэй цэцэрлэгийн модон барилгыг нэгдлийн төлөө бригадын гишүүдийн хүчээр баригдаж ашиглалтанд оруулжээ.



1976 онд сумын төв Хүйсийн голд нүүн ирж төвлөрөхөд 50 хүүхдийн тоглоом сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Жилдээ 50 хүүхэд хүлээн авч сургалт хүмүүжлийн ажлыг явуулдаг. Байгууллагын бүтэцийн хувьд 2 багш, нийт 10 орон тоотой жилдээ улсаас 35-45 сая төгрөгийн төсөвтэй ажилладаг болсон байна.

Анхны эрхлэгч Ё.Норжин нь 1951 онд Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Гуулингийн бригадад төрсөн. 1959- 1963 онд Өлзийт сумын бага сургууль, Хужирт сумын дунд сургуулийг төгссөн.





**Эрхэм зорилго:**

Хүүхэд бүрт урам  
хайрлая

Хүн бүрт итгэл  
төрүүлье

Хамт олноороо  
шийдэлд хүрье.



# Алсын хараа:

Мэргэжлээрээ хөрвөж  
ажиллах чадварлаг багш,  
ажиллагсадаар хангагдаж,  
сургуулийн өмнөх  
боловсролыг чанар  
хүртээмжтэй явуулж, эцэг  
эх, иргэдийн талархлыг  
хүлээсэн байгууллага  
болно.



# Үзэл баримтлал:

Хүүхдийн хүсэл  
сонирхол, хэрэгцээнд  
тулгуурласан тэдний  
чөлөөт байдал идэвхтэй  
үйл ажиллагааг дэмжиж  
ардын уламжлалт, ёс  
заншил болон тоглоомоор  
сурч, хөгжиж төлөвших